



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 05 сарын 29 өдөр

Дугаар 11242

Арвайхээр

Г Хүнс, ахуйн өргөн хэрэглээний бараа  
бүтээгдэхүүнийг хоногийн 24 цагаар худалдаалах  
эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн “г”, “ж”, 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 40, 43 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хүн амын тоо, төвлөрөл, хэрэглэгч, үйлчлүүлэгчдийн эрэлт, хэрэгцээ, нутаг дэвсгэрийн онцлогийг харгалзан хүнс, ахуйн өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний худалдаа, үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох аж ахуйн нэгжүүдийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн хавсралтад заасан аймгийн төв Арвайхээр сумын 2, Хархорин сумын 2 аж ахуйн нэгж, иргэнд 24 цагаар хүнс, ахуйн өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний худалдаа, үйлчилгээ эрхлэхийг зөвшөөрсүгэй.

2.Дээрх аж ахуйн нэгжүүдэд үйл ажиллагаанд хууль тогтоомж холбогдох дүрэм журам, стандартыг мөрдлөг болгон ажиллахыг даалгасугай.

3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Арвайхээр сумын Засаг дарга (О.Пүрэвдорж), Хархорин сумын Засаг дарга (Л.Энхбат), аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн), Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа О.Ганбат)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100539

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2020 оны 05  
дугаар сарын 20-ны өдрийн дугаар  
захирамжийн хавсралт

ХҮНС, АХУЙН ӨРГӨН ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ  
ХОНОГИЙН 24 ЦАГААР ХУДАЛДААЛАХ ЭРХ ӨЛГОХ ХҮСЭЛТ  
ГАРГАСАН АЖ АХУЙ НЭГЖИЙН СУДАЛГАА

№	Хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Дэлгүүр болон үйлчилгээний газрын нэр	Хаяг
1.	“Гүн арвай” хүнсний дэлгүүр	“Хөгшин хайрхан шүтээн” ХХК	Арвайхээр сум
2.	“Оюу төв” хүнсний дэлгүүр	“Оюу-Шүтээн” ХХК	Арвайхээр сум
3.	“Баялаг -2” хүнсний дэлгүүр	“Типстарс” ХХК	Хархорин сум
4.	“Орхон түшээ” супер маркет	“Дулаанхангай хоршоо”	Хархорин сум

-оOo-